

Аньсны ханд, шээсний замын архаг халдварт өвчинд нөлөөлөх нь

Англи хэлнээс орчуулсан М.Ууганжаргал (докторант)

ЭЗШУИС, Ерөнхий эрдмийн тэнхим

Нийт эмэгтэйчүүдийн бараг тэн хагас нь амьдралдаа шээсний замын халдварт өвчинд нэг удаа боловч өртдөг байна. Энэ өвчин нь олон удаа давтагдсаны улмаас архагшдаг бөгөөд иймээс антибиотикийн бус, урьдчилан сэргийлэх эмчилгээ хэрэгтэй болдог билээ.

Аньс, аньсны жүүс, аньсны ханд нь нэг жилийн хугацаанд 2-3 удаа тохиолдох шээсний замын архаг үрэвслийг эмчлэх түүнээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй онцгой сайн бэлдмэл юм. Гэхдээ аньсны төрлийн бүх жимсний үзүүлэх нөлөө харилцан адилгүй гэдгийг эмнэлзүйн судалгаа анхааруулж байна.

Судлаачдын баг уг жимсний номхруулсан хандыг дахин нягтлан судалж, шээсний замын архаг өвчтөнд аньсны хандын үзүүлэх нөлөөний ач холбогдолыг тооцох бичил жингийн нарийвчилсан судалгааг түлхүү хөгжүүлж байна. Судлаачид 44 өвчтөнийг судалгаанд хамруулсан бөгөөд өвчтөнүүдийн тэн хагас нь аньсны хандан капсулыг 2 сарын хугацаанд өдөр тутам амаар ууж хэрэглэн эрүүл ахуйн зөвлөмжид тулгуурласан амьдралын хэвшлийг дагаж мөрдөн, юм уух болон шээс ялгаруулалт, кафейны өөрчлөлт, согтууруулах ундаа халуун ногооны хэрэглээний зөвлөмжийг даган биеийн идэвхтэй үйл ажиллагааг зохицуулах зааварчилгаануудыг дагаж мөрдсөн байна. Үлдсэн 22 өвчтөн хяналтын бүлэгт хамрагдаж зөвхөн амьдралын хэвшлээ өөрчлөх зөвлөгөөг дагасан байна.

Аньсны хандыг амаар ууж хэрэглэсэн өвчтөнүүдийн шээсний замын халдварт өвчний тохиолдол өмнөх 2 сартай харьцуулахад 73,3 % иар буурсан үзүүлэлттэй байхад хяналтын бүлгийнхэний зөвхөн 15,4% хувьд нь өвчний тохиолдол буурсан үзүүлэлттэй байна.

Шээсний замын архаг халдвар өвчин нь эмэгтэйчүүдийн хувьд үнэхээр зовиуртай байдаг бөгөөд өвчний шинж тэмдгийн бууралтын хэмжээ нь клиникийн эмч нарын анхаарлыг татаж байна. Аньсны нэмэлт тэжээлийн бүлгийн 7 эмэгтэйд ямарч шинж тэмдэг илрээгүй бөгөөд харин хяналтын бүлгийхэнд илэрсэн бүх шинж тэмдгүүд нь тэмдэглэгдэж үлдсэн. Аньсны нэмэлт тэжээлийн бүлгийнхэний 13,6%

хувьд нь, хяналтын бүлгийхэний 36,3% хувьд нь шээсний замын халдварт өвчний талаарх эмнэлзүйн зөвлөгөө шаардлагатай болсон байна.

Аньсны нэмэлт тэжээлийн бүлгийн өвчтөнүүдэд 2,5 өдөр өвчний шинж тэмдэг илэрсэн гэж мэдээлсэн бөгөөд хяналтын бүлгийхэн 5 аас илүү өдөр өвчний шинж тэмдэг илэрсэн гэж мэдэгджээ. Судалгааны дүгнэлтээр аньсны нэмэлт тэжээлийн бүлгийн 90,9% буюу 22 өвчтөний 20-д нь шээсний шинжилгээний хариу сөрөг гарсан ба хяналтын бүлгийн 22 ийн 11 ба 50% -д нь сөрөг гэсэн хариу гарчээ.

Эмчилгээтэй холбоотой сөрөг үр дагавар илрээгүй.

Иймээс судлаачид аньсны хандан нэмэлт тэжээлийн бүтээгдэхүүнийг хэрэглэснээр шээсний замын архаг үрэвсэлтэй эмэгтэйчүүд эмнэлгийн тусламж үйлчилгээ авах болон антибиотикийн хэрэглээгээ багасгах боломжтой гэсэн дүгнэлтэнд хүрсэн.